# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 31 (508)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Далай ашиглах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *"Парламентын ордон барих төсөл"-ийн буцалтгүй тусламжийн харилцан ойлголцлын санамж бичгийг соёрхон батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2007 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2007 оны наймдугаар сарын 21 №31 (508)


## Гарчиг


### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | | |
|---|---|---|---|
| 372. | Далай ашиглах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 737 |
| 373. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 739 |
| 374. | Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 740 |
| 375. | "Парламентын ордон барих төсөл"-ийн буцалтгүй тусламжийн харилцан ойлголцлын санамж бичгийг соёрхон батлах тухай | | 740 |
| 376. | Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай | | 740 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 377. | Ерөнхийлөгчийн хоригийн тухай | Дугаар 55 | 741 |
| 378. | Хууль тогтоолын төсөл буцаах тухай | Дугаар 57 | 742 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 379. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 161 | 742 |
| 380. | Др. Ёохан Заксыг "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 162 | 743 |
| 381. | Гарьдын Баасанжавт Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай | Дугаар 163 | 743 |
| 382. | Сэрээнэнгийн Дашзэвэгт Монгол Улсын худалдааны гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 164 | 743 |
| 383. | Цэдээгийн Жанчивт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай | Дугаар 165 | 744 |
| 384. | Кикүчи Тошиог "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 169 | 744 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 385. | Иргэний зарим хэргийн харьяаллыг захиргааны хэргийн харьяаллаас зааглан ялгах тухай | Дугаар 32 | 744 |


## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2007 оны 08 дугаар сарын 02-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ДАЛАЙ АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Далай ашиглах тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7, 8, 9 дэх заалт:**

"4.1.7."ахмад" гэж далай ашиглах үйл ажиллагааг аюулгүй хэрэгжүүлэхийн тулд хөлөг онгоц, багийн бүрэлдэхүүнийг хөлөг онгоцны өмчлөгч, эзэмшигчдийн өмнө хариуцан удирдаж буй этгээдийг;

4.1.8."хөлөг онгоцны баг" гэж хөлөг онгоцны аюулгүй ажиллагааг хангах үүрэг бүхий мэргэжлийн этгээдийг;

4.1.9."хөлөг онгоцыг дангаар нь түрээслэх" /бербоут- чартер/ гэж түрээслэгч хөлөг онгоцыг өөрийн эзэмшил, ашиглалтад авч түүнд бүрэн хяналт тавьж, хөлөг онгоцны ахмад болон багийн бүрэлдэхүүнийг сонгож томилох эрхтэйгээр хөлөг онгоцыг түрээслэгчид шилжүүлж байгаа албан ёсны гэрээг."

**2/ $8^{1}$ дүгээр зүйл:**

**"$8^{1}$ дүгээр зүйл. Далайн захиргаа**

$8^{1}$.1.Монгол Улсын далайн захиргаа байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн шийдвэрлэнэ.

$8^{1}$.2.Далайн захиргаа нь үйл ажиллагааныхаа орлого болон улсын төсвөөс хуваарилсан хөрөнгөөр санхүүжинэ.

$8^{1}$.3.Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн боомт нь Улаанбаатар хот байна."

**3/ 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

"7.2.Энэ зорилгоор хөлөг онгоцны олон улсын техникийн хяналтын байгууллага, нарийн мэргэшсэн мэргэжлийн бусад байгууллага, шинжээчийг томилно."

**4/ 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:**

"11.5.Гадаад улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцыг дангаар түрээслэх гэрээгээр эзэмшиж байгаа, уг хөлөг онгоц нь зохих мэргэжил боловсрол эзэмшсэн, дадлага туршлагатай багаар хангагдсан бол түүнийг нэг удаагийн аяллын гэрээг үргэлжлүүлэх хугацаанд дангаар түрээсэлсэн хөлөг онгоц гэж үзэж Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ."

5/ **13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

"13.3.Хөлөг онгоцонд дараахь гэрчилгээг заавал байрлуулна:

13.3.1. хөлөг онгоцыг даатгагч байгууллагаас олгосон албан ёсны нэр, хаяг, давхар даатгагдсан тохиолдолд хөлөг онгоцноос далайд учруулсан бохирдлыг хариуцах давхар даатгагч байгууллагын албан ёсны нэр, хаягтай гэрчилгээ;

13.3.2.Монгол Улс олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон болохыг баталгаажуулсан гэрчилгээ;

13.3.3.Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий этгээдийг заасан гэрчилгээ."

**6/ 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:**

"14.2.Хөлөг онгоцны багийн гишүүн дараахь үүрэгтэй:

14.2.1.хөлөг онгоц, түүн дээр байгаа этгээдийн аюулгүй байдалд хор хохирол учруулахгүйгээр үүргээ хэрэгжүүлэх;

14.2.2.өөрийн мэдсэн буюу олж илрүүлсэн хөвөлтийн аюулгүй байдалд хор хөнөөл учруулж болзошгүй аливаа аюулыг ахмадад мэдээлэх;

14.2.3.үүргээ бүрэн дүүрэн биелүүлэх чадварт нь нөлөөлөх нөхцөл байдал үүсгэсэн аливаа өөрчлөлтийн талаар ахмадад мэдээлэх;

14.2.4.ахмадын хууль ёсны тушаал, шаардлагыг биелүүлэх."

**2 дугаар зүйл**.Далай ашиглах тухай хуулийн 3.1-ийн "үйл ажиллагаа явуулах" гэсний дараа "байгууллага," гэж, мөн хэсгийн "аж ахуйн нэгжид" гэсний дараа "улсын харьяалал," гэж, 4.1.3-ын "үйл ажиллагаа явуулах" гэсний дараа "байгууллага," гэж, 8 дугаар зүйлийн гарчгийн "үйл ажиллагаа явуулах" гэсний дараа "байгууллага," гэж, мөн зүйлийн 8.1-ийн "Аж ахуйн нэгж" гэсний өмнө "Байгууллага," гэж, мөн зүйлийн 8.2, 8.3-т "үйл ажиллагаа явуулах" гэсний дараа "байгууллага," гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл**.Далай ашиглах тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

"1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далайн баялаг олборлох, загас агнах, тээвэр хийх зэрэг далай ашиглах үйл ажиллагаа явуулах, далай дахь аюулгүй байдлыг хангах, далайн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино."

**2/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт**:

"4.1.2."бүртгэгч" гэж хөлөг онгоцыг бүртгэх чиг үүрэг бүхий Далайн захиргааны нэгжийг;"

**3/ 9 дүгээр зүйл:**

**"9 дүгээр зүйл. Далайн захиргааны чиг үүрэг**

9.1. Далайн захиргаа нь Монгол Улсын олон улсын гэрээний дагуу дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.далай ашиглах үйл ажиллагааны удирдлагаар хангаж, хяналт тавих;

9.1.2.хөлөг онгоцны байгууламж, хөдөлгүүр, бусад тоног төхөөрөмжид техникийн хяналт тавих;

9.1.3.хөлөг онгоцон дээр ажиллагсад, зорчигчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;

9.1.4.далай ашиглах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

9.1.5.хөлөг онгоцноос далайг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, бохирдсон үед холбогдох арга хэмжээ авах;

9.1.6.далайн чиглэлээр дотоод, гадаадын холбогдох байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулах, мэргэжилтэй ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх;

9.1.7.гадаад орны эрх бүхий байгууллагаас олгосон далайчны үнэмлэхийг хүлээн зөвшөөрөх;

9.1.8.хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнд ажиллах үндэсний боловсон хүчний ойрын болон хэтийн хэрэгцээг тодорхойлох, түүнийг олон улсын зохих гэрээнд нийцүүлэн бэлтгэх ажлыг зохион байгуулах.

9.2.Энэ хуулийн 9.1.1-9.1.6 дахь заалтыг Далайн захиргаа олон улсын холбогдох эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ, хэлцэл байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

9.3.Хөлөг онгоц бүртгэх журмыг Засгийн газар батална."

**4/ 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:**

"11.2.Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулсан Олон Улсын хөлөг онгоцны техникийн хяналтын байгууллагаар техникийн үзлэг хяналт хийлгэсний дараа хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэнэ."

**5/ 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

"16.3.Байгалийн онцгой аюул, давагдашгүй хүчин зүйлийн улмаас хөлөг онгоц, түүний дээрх ачаа, эд хөрөнгөд учирсан хохирлыг Монгол Улсын олон улсын гэрээнд заасан журмын дагуу зохицуулна."

**6/ 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

"18.3.Хөлөг онгоц мөргөлдсөний улмаас болон түүнийг аврах ажиллагааны үед учирсан эд хөрөнгийн хохирлыг Монгол Улсын олон улсын гэрээнд заасан журмын дагуу зохицуулна."

**4 дүгээр зүйл**.Далай ашиглах тухай хуулийн 4.1.4-ийн "Регистр" гэснийг "хөлөг онгоцны техникийн хяналтын байгууллага" гэж, Дөрөвдүгээр бүлгийн гарчгийг "Хөлөг онгоц, түүний баг, хөлөг онгоцны аюулгүйн үйл ажиллагаа, далайг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх" гэж, 10 дугаар зүйлийн гарчиг, 10.1 дэх хэсгийн "бүртгэлийн боомт" гэснийг "бүртгэгч" гэж, 11.1 дэх хэсгийн "Бүртгэлийн боомт" гэснийг "Далайн захиргаа" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Далай ашиглах тухай хуулийн 4.1.6, 10.1.4, 10.1.5-ыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2007 оны 08 дугаар сарын 02-ны өдөр** **Улаанбаатар хот**

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**.Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 9 дэх заалтын "далайн болон усан замын тээврийн асуудал" гэснийг "далай ашиглах болон усан замын тээврийн асуудал" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл**.Энэ хуулийг Далай ашиглах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2007 оны 08 дугаар сарын 02-ны өдөр** — **Улаанбаатар хот**

### ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлээр өөрчлөн найруулсан 7.1 дэх хэсгийн "512 бөх барилдах бөгөөд" гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлээр өөрчлөн найруулсан 7.2 дахь хэсгийн "бөгөөд" гэснийг "тохиолдолд" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"**4 дүгээр зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10.2, 12.4.5, 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

"10.2.Энэ хуулийн 7.1, 7.2-т заасан барилдааны шөвгийн 16-д үлдсэн бөх, 9.2-т заасан үндэсний сур харвааны эхний 3 байр эзэлсэн харваачийг сэргээшийн шинжилгээнд заавал оруулна."

**2/ 12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 5 дахь заалт:**

"12.4.5.бөх, харваачийг энэ хуулийн 10.2-т заасан сэргээшийн шинжилгээнд оруулах ажлыг зохион байгуулах;"

**3/ 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

"14.3.Энэ хуулийн 10.2-т заасан шинжилгээгээр бөх, харваач сэргээш хэрэглэсэн нь тогтоогдвол тухайн баяр наадамд олгосон цол, байрыг хасна."

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2007 оны 08 дугаар сарын 03-ны өдөр** — **Улаанбаатар хот**

### "ПАРЛАМЕНТЫН ОРДОН БАРИХ ТӨСӨЛ"-ИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧГИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сангийн хооронд 2007 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан "Парламентын ордон барих төсөл"-ийн буцалтгүй тусламжийн харилцан ойлголцлын санамж бичгийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2007 оны 08 дугаар сарын 03-ны өдөр** — **Улаанбаатар хот**

### ХОХИРЛЫГ ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛӨӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулиар хадгаламж зээлийн зарим хоршооны үүсгэн байгуулагчдын буруутай үйл ажиллагааны улмаас хадгаламж эзэмшигчдэд учирсан хохирлын тодорхой хэсгийг төрөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль тогтоомж**

2.1.Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Иргэний хууль[1], Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай[2] хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хууль нь хууль хүчин төгөлдөр болохоос өмнө эрүүгийн хэрэг үүсгэж, шүүхийн шийтгэх тогтоолоор хохирлынх нь бодит хэмжээг тогтоосон хадгаламж зээлийн хоршооны хохирогчдод хамаарна.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан бодит хохиролд хадгаламжийн хүү үл тооцно.

**4 дүгээр зүйл. Хохирол барагдуулах хэмжээ**

4.1.Энэ хуулийн 3 дугаар зүйлд зааснаар тогтоогдсон хохирлын 50 хувийг төрөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулна.

**5 дугаар зүйл. Хохирол барагдуулах эх үүсвэр, түүнийг нөхөн бүрдүүлэх**

5.1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан хохирлыг улсын төсвийн хөрөнгөөр барагдуулна.

5.2.Энэ хуулийн 5.1-д заасны дагуу улсын төсвийн хөрөнгөөс барагдуулсан хохирлыг тухайн хоршооны дараахь орлого, мөнгөн хөрөнгөөс түүнд ногдох хэмжээгээр нь нөхөн төлүүлнэ:

5.2.1.төлбөр төлөгчөөс гаргуулан авсан бэлэн мөнгө;

5.2.2.харилцах дансан дахь төгрөг, гадаад валют;

5.2.3.төлбөр төлөгчөөс хураан авсан хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлого;

5.2.4.үнэт цаас борлуулсны орлого;

5.2.5.газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг худалдан борлуулснаас олсон орлого;

5.2.6.ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу худалдан борлуулснаас олсон орлого;

5.2.7.хоршооны үйл ажиллагааны орлого;

5.2.8.бусад орлого.

5.3.Энэ хуулийн 5.2-т заасан орлого, мөнгөн хөрөнгийг эхний ээлжинд улсын төсөвт шилжүүлэх бөгөөд уг ажиллагаа энэ хуулийн 4.1-д заасан төлбөрийг улсын төсөвт буцаан төлж дуусгах хүртэлх хугацаанд үргэлжилнэ.

5.4.Энэ хуулийн 5.3-т заасан орлого, мөнгөн хөрөнгө хуваарилах ажиллагаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49.3, 70.1 дэх хэсэгт хамаарахгүй.

**6 дугаар зүйл. Хохирол барагдуулах журам**

6.1.Хохирол барагдуулах журмыг Засгийн газар батална.

**7 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

7.1.Энэ хуулийг 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2007 оны 08 дугаар сарын 02-ны өдөр** | **Дугаар 55** | **Улаанбаатар хот**

**Ерөнхийлөгчийн хоригийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 29.1-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурал 2007 оны 7 дугаар сарын 6-ны өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл, хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

[1] Иргэний хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн
[2] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 08 дугаар сарын 03-ны өдөр | Дугаар 57 | Улаанбаатар хот

### Хууль, тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 17.3.7-г үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог, Э.Бат-Үүл, Ц.Жаргал, Ц.Мөнх-Оргил, С.Оюун, С.Отгонбаяр нараас 2007 оны 7 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, "Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул эдгээр төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 06-ны өдөр | Дугаар 161 | Улаанбаатар хот

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт осолдсон Ми-8 нисдэг тэргийг эрж хайх, хүмүүсийг аврах ажиллагаанд мэргэжлийн өндөр ур чадвар, идэвх зүтгэл гарган ажилласан дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

Базарын Цээпилдорж - Сэлэнгэ аймгийн Мандал сумын Засаг дарга

**ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:**

1. Аварзэдийн Амарболд - ОБЕГ-ын шуурхай бүлгийн тасгийн дарга, шадар ахмад
2. Дапхаагийн Баатарзоригт - ОБЕГ-ын хяналт мониторингийн тевийн дарга, дэвд ахмад
3. Думаагийн Намсрай - ОБЕГ-ын Аврах тусгай ангийн Захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэвд ахмад

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Даржаагийн Байгал - Иргэний агаарын тээврийн "Сентрэл Монголия Эйрвэйз" ХХК-ийн Ми-8 нисдэг тэрэгний нисэх багийн дарга
2. Чимэдбазарын Буянбадрах - Иргэний агаарын тээврийн "Тэнгэрийн улаач шинэ" ХХК-ийн Ми-8 нисдэг тэрэгний багш-нисгэгч

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Лодойхүүгийн Будсүрэн - ОБЕГ-ын харьяа аврах тусгай ангийн агаар десантын отрядын шүхэрчин гал сөнөөгч, тэргүүн түрүүч
2. Хашхүүгийн Сүхбаатар - ОБЕГ-ын харьяа аврах тусгай ангийн агаар десантын отрядын шүхэрчин гал сөнөөгч

**"ШУДАРГА ЖУРАМ" МЕДАЛИАР:**

1. Банзрагчийн Адъяатөр - ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн агаар десантын отрядын шүхэрчин гал сөнөөгч, шадар түрүүч
2. Жавзангийн Бадамжунай - ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн шүхэр, шүхрийн дагалдах хэрэгслийн техникч

3. Сандуйжавын Батдалай - ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн агаар десантын отрядын хэсгийн зааварлагч

4. Хурцболдын Бат-Энх - ОБЕГ-ын Шуурхай бүлгийн химичин аврагч, шадар түрүүч

5. Цэдэнбалын Баярцогт - ОБЕГ-ын Шуурхай бүлгийн гал сөнөөгч, дэд түрүүч

6. Ганбатын Ганжигүүр - ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн агаар десантын отрядын шүхэрчин гал сөнөөгч

7. Төмөрбаатарын Мөнхтөр - ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн агаар десантын отрядын шүхэрчин гал сөнөөгч

8. Дамдинсүрэнгийн Пүрэвдорж - ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн агаар десантын отрядын нисэн ажиглагч-салааны захирагч

9. Ядамбатын Сэргэлэн - ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн агаар десантын отрядын хэсгийн зааварлагч, дэд түрүүч

10. Пунцагийн Цогжаргал - ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн агаар десантын отрядын шүхэрчин гал сөнөөгч

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2007 оны 07 дугаар сарын 06-ны өдөр** | **Дугаар 162** | **Улаанбаатар хот**

### Др.Ёохан Заксыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Австри Улсын найрамдалт харилцааг өргөжүүлэх, хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол-Австрийн Засгийн газар хоорондын хамтарсан комиссын Австрийн хэсгийн дарга, Австрийн Эдийн засаг, хөдөлмөрийн яамны Эдийн засгийн гадаад харилцааны ерөнхий захирал ноён Др.Ёохан Заксыг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2007 оны 07 дугаар сарын 06-ны өдөр** | **Дугаар 163** | **Улаанбаатар хот**

### Гарьдын Баасанжавт Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээх тухай

Орон нутгийн болон төр захиргааны төв байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд удирдлагын шинэ арга хэлбэрийг нэвтрүүлж, орон нутгийг хөгжүүлэх, ХАА-н салбарын санхүүгийн зах зээлийг өргөтгөх, улсын сан хөмрөгийг нэмэгдүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж "Дэлгэржаргал" ХХК-ийн зөвлөх Гарьдын Баасанжавт Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2007 оны 07 дугаар сарын 09-ний өдөр** | **Дугаар 164** | **Улаанбаатар хот**

### Сэрээнэнгийн Дашзэвгт Монгол Улсын худалдааны гавъяат ажилтан цол хүртээх тухай

Орон нутгийн худалдааны байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, иргэдийг хүнс, өргөн хэрэглээний бараагаар хангах, "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж Завхан аймгийн Цагаанхайрхан сумын "Бидэр хайрхан" ХХК-ийн захирал Сэрээнэнгийн Дашзэвгт Монгол Улсын худалдааны гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2007 оны 07 дугаар сарын 09-ний өдөр** **Дугаар 165** **Улаанбаатар хот**

### Цэдээгийн Жанчивт Монгол Улсын гавъяат уурхайчин цол хүртээх тухай

Түлш, эрчим хүч, геологи, уул уурхайн болон бусад салбарт гарсан аюул ослыг арилгах, урьдчилан сэргийлэх албанд тасралтгүй 35 жил зүтгэж, түүний удирдлагаар гэнэтийн осол аваараас 155 хүний амь насыг аварсан ба 2007 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Налайхын уурхайд гарсан нуралтаас 8 хүний амь насыг аврах ажлыг амжилттай зохион байгуулсан Уул уурхайн аврах албаны дарга Цэдээгийн Жанчивт Монгол Улсын гавъяат уурхайчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2007 оны 07 дугаар сарын 10-ны өдөр** **Дугаар 169** **Улаанбаатар хот**

### Кикүчи Тошиог "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол-Японы харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монголын нийгэм, эдийн засгийн салбарт тулгамдсан асуудлуудыг судалж шийдвэрлэхэд чиглэсэн хоёр талын хамтын ажиллагаанд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Японы Эдийн засгийн нэгдсэн холбооны тэргүүн, профессор ноён Кикүчи Тошиог "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

**2007 оны 07 дугаар сарын 02-ны өдөр** **Дугаар 32** **Улаанбаатар хот**

### ИРГЭНИЙ ЗАРИМ ХЭРГИЙН ХАРЬЯАЛЛЫГ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ХАРЬЯАЛЛААС ЗААГЛАН ЯЛГАХ ТУХАЙ

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4, 36 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4.-т заасан захиргааны болон иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхэд учирч буй бэрхшээлийг арилгах, дээрх хуулиудын холбогдох зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ НЬ:**

Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах нь иргэдэд Үндсэн хуулиар олгогдсон эрх тул дагнасан болон ерөнхий харьяаллын шүүхүүд хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэд, хуулийн этгээдийн гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэхдээ тухайн шүүхүүдийн хянан шийдвэрлэх маргааны харьяаллын талаар нэгдсэн ойлголттой байж, бусдыг чирэгдүүлэхгүй, шүүн таслах ажиллагааны чиглэл тус бүрээр үйл ажиллагаа явуулахыг онцгой анхаарах нь зүйтэй юм.

Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд зааснаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэдэг дагнасан шүүх байгуулагдсан явдал нь иргэдийн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа болох шүүхийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн тул хэргийн харьяаллын талаар шүүхүүд ул ойлголцох, хэрэг, маргааныг шийдвэрлэх шат, дамжлагыг нэмэгдүүлэх, бусдыг чирэгдүүлэх үндэслэл, шалтгааныг үүсгэж болохгүй.

#### 1.Шүүхэд мэдүүлэх эрх

**1.1.**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.-д **"Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын**

**дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй"**, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд **"хуульд тусгайлан заасан, дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн, захиргааны байгууллага албан тушаалтан энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг биелүүлээгүй, шууд харьялах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй, харьялах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байхгүй бол...иргэн, хуулийн этгээд захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй"** гэж тус тус заасны дагуу Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд шүүхэд эрхээ хамгаалуулахаар хандах эрхтэй.

Иргэний хэрэг үүсгүүлэх тухай гомдол, захиргааны хэрэг үүсгүүлэх тухай нэхэмжлэлийг зөвхөн иргэн гаргах эрхтэй гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй болно.

**1.2.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4.-т заасан **"захиргааны байгууллага, албан тушаалтан"**, мөн хуулийн 156 дугаар зүйлийн 156.1.1.-д заасан **"төрийн захиргааны байгууллага, тэдгээрийн албан тушаалтан"** гэдэгт:

а/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д зааснаас бусад байгууллага, албан тушаалтныг;

б/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтныг зөвхөн мөн зүйлийн 4.2.-т зааснаас бусад эрхийн акт гаргасан тохиолдолд тус тус хамааруулна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх зүйл, заалтад туссан **"эрх зүйн акт"**, **"шийдвэр, үйл ажиллагаа"** гэдэгт Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.-т заасан **"зөвхөн гадагш /бусдаас/ дагаж мөрдөх буюу заавал биелүүлэх"**, нийтийн эрх зүйн захиргааны актаас бусад шийдвэр, үйл ажиллагааг багтаан ойлгоно.

**1.3.**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4.-т заасан үндэслэлээр иргэний хэрэг үүсгэх **"гомдол"** нь мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.-д зааснаар **"нэхэмжлэл"** гэх нэгдсэн нэр томьёонд багтаж байгаа тул иргэний хэрэг үүсгэх үндэслэл болох гомдолд энэ хуульд заасан нэхэмжлэлд тавигддаг бүх шаардлага нэгэн адил хамааралтай байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7., 3.1.8.-д **"нэхэмжлэл"** болон **"гомдол"** гэсэн нэр томьёог тус тус тодорхойлсны дагуу захиргааны хэрэг үүсгүүлж, зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд хандаж гаргасан өргөдлийг нэхэмжлэл гэнэ.

**2.Нэхэмжлэл хүлээн авах**

Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж буй этгээдийн нэхэмжлэлийг дагнасан болон ерөнхий харьяаллын шүүхүүд хүлээн авахдаа тухайн нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэргийн болон шүүхийн харьяаллын дагуу гаргасан эсэхийг шалган шийдвэрлэж байвал зохино.

**2.1.Хэргийн харьяалал**

Хэргийн харьяалал гэж тухайн маргаан ямар байгууллагаар шийдвэрлэгдэхийг тодорхойлдог, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бол шүүх уг асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй эсэхийг тогтоодог ойлголт юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд иргэний хэрэг шийдвэрлэх ерөнхий харьяаллын шүүхэд энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан нэхэмжлэлтэй маргаан шийдвэрлэгдэхийг зааснаас гадна шүүх болон арбитрын харьяаллыг зааглах тухай тусгасан байна.

Харин иргэний хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий харьяаллын шүүх болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх дагнасан шүүхэд хамаарах асуудлын хүрээг заагласан зохицуулалт уг зүйлд тусгагдаагүй хэдий ч энэ асуудал нь шүүхийн биш харин хэргийн харьяалалд хамаарах болно.

**2.1.1.** Иргэний хэрэг хянан шийдвэрлэдэг ерөнхий харьяаллын шүүхүүд нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1., 4.2.-т зааснаас бусад этгээдэд холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4., 13 дугаар зүйлд зааснаар хүлээн авч, мөн хуулийн арвандөрөвдүгээр бүлэгт заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

а/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасанаас бусад байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой нэхэмжлэл.

Эдгээрт төрийн захиргааны бусад байгууллага, тэдгээрийн албан тушаалтан

хамаарахаас гадна төрийн захиргааны бус бусад байгууллага, хуулийн этгээд, тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа хамаарна.

б/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.-т зааснаар мөн зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтны гадагш чиглэгдсэн, нийтийн эрх зүйн хүрээний актаас бусад шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой нэхэмжлэл тус тус хамаарна.

**2.1.2**. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх дагнасан шүүхүүд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12, 13 дугаар зүйлүүдэд заасан иргэний шүүн таслах ажиллагааны журмаар шийдвэрлэгдэх хэргээс бусад Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ.

а/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанаас учирсан эд хөрөнгийн хохирлын талаар нэхэмжлэлийн шаардлага гарсан, хохирлын хэмжээ тогтоогдсон бөгөөд энэ талаар маргаангүй бол захиргааны хэргийн шүүх энэ хуулийн 70 дугаар зүйлийн 70.4.-т зааснаар уг шаардлагыг үндсэн нэхэмжлэлийн хамт шийдвэрлэнэ.

б/ Байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах талаарх шаардлага захиргааны хэргийн шүүхэд үндсэн нэхэмжлэлийн хамт гараагүй бөгөөд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарснаас хойш хохирлын талаар гаргасан нэхэмжлэлийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэнэ.

Энэ тохиолдолд уг нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арван дөрөвдүгээр бүлэгт заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 18 дугаар зүйлийн 1-ийн 5 дахь заалт нэгэн адил хамаарна.

**2.1.3.**Иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хэргийн харьяалал зөрчигдсөн тохиолдолд дагнасан болон ерөнхий харьяаллын шүүхүүд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад заасны дагуу асуудлыг шийдвэрлэнэ.

а/ Захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах нэхэмжлэлийг хүлээн авсан ерөнхий харьяаллын шүүх иргэний хэрэг үүсгээгүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1.-д зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай шүүгчийн захирамжид хэргийн харьяалал зөрчигдсөн байдал, үндэслэлийг заахын зэрэгцээ захиргааны хэргийн шүүхэд хандах эрхийг мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.2.-т зааснаар тусгасан байвал зохино.

б/ Захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах нэхэмжлэлийг хүлээн авсан ерөнхий харьяаллын шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзалгүй иргэний хэрэг үүсгэсэн бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1.-д зааснаар шүүх хуралдаанаар хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гаргана.

Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид хэргийн харьяалал зөрчигдсөн байдал, үндэслэл, захиргааны хэргийн шүүхэд хандах эрхийг тусгана.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2.-т заасан хэрэг шилжүүлэх ажиллагаа нь шүүхийн харьяалал зөрчигдсөн тохиолдолд хамааралтай тул хэргийн харьяалал зөрчигдсөн тухайн нөхцөлд хамааралгүй болно.

в/ Ерөнхий харьяаллын шүүхэд харьяалагдах нэхэмжлэлийг хүлээн авсан захиргааны хэргийн шүүх хэрэг үүсгээгүй бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1.-д зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана. Харин энэ хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.-д зааснаар нэхэмжлэлийг холбогдох ерөнхий харьяаллын шүүхэд **"шилжүүлнэ"** гэдгийг тухайн асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй ерөнхий харьяаллын шүүхийг захирамжид заана гэж ойлгоно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.-д зааснаар нэхэмжлэлийг ерөнхий харьяаллын шүүхэд шилжүүлэх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1.-д заасан шаардлагыг зөрчих тул мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.11.-д зааснаар ерөнхий харьяаллын шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл үүсэж, нэг нэхэмжлэлийг хоёр шүүх хэргийн харьяаллаас шалтгаалан хүлээн авахаас давхар татгалзсанаар шүүхэд эрхээ хамгаалуулахаар хандсан иргэн, хуулийн этгээдийг чирэгдүүлэх шалтгаан болно.

Нөгөө талаар эрхээ хамгаалуулахаар тухайн шүүхэд хандах эсэхийг нэхэмжлэгч өөрөө шийдвэрлэдэг иргэний хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны диспозитив зарчим зөрчигдөж болзошгүйг шүүхүүд анхаарах учиртай.

г/ Ерөнхий харьяаллын шүүхэд харьяалагдах нэхэмжлэлийг хүлээн авсан захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзалгүй захиргааны хэрэг үүсгэсэн бөгөөд хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад энэ байдал илэрсэн бол:

- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтанд холбогдолгүй асуудлаар гарсан нэхэмжлэл бол тэдгээрт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэнэ. Харин шүүх шийдвэртээ нэхэмжлэлийг ямар шүүхэд хэрхэн мэдүүлэх талаар тусгасан байна;

- Нэхэмжлэгчийн сонгосон хариуцагч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтан биш, мөн зүйлийн 4.2.-т заасан захиргааны актаас бусад шийдвэр, үйл ажиллагааны талаар гаргасан нэхэмжлэлийг шүүх нэгэнт хүлээн авч, захиргааны хэрэг үүсгэсэн тул хүлээн авахаас татгалзаж болохгүй. Харин үүсгэгдсэн захиргааны хэргийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлийн дагуу шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гаргаж, хэрэгсэхгүй болгоно. Тухайн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд заасан журам хамаарахгүй болно.

д/ Хэргийн харьяалал зөрчигдсөн байдал дагнасан болон ерөнхий харьяаллын давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илэрвэл:

-захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.3.-т зааснаар шийдвэрийг хүчингүй болгоно.

Ингэхдээ **"хэргийг харьяалагдах шүүхэд нь шилжүүлнэ"** гэдэг нь зөвхөн шүүхийн харьяалал зөрчигдсөн тохиолдолд хамаарах тул холбогдох захиргааны хэргийн шүүхэд шилжүүлнэ.

Харин тухайн нэхэмжлэл ерөнхий харьяаллын шүүхээр шийдвэрлэгдэх ёстой бөгөөд хэргийн харьяалал зөрчигдсөн бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.1-д зааснаар шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Нэхэмжлэлийн дагуу захиргааны хэрэг үүсгэгдэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа анхан болон давж заалдах шатны шүүх явуулж дууссан үед нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж болохгүй.

Шүүхийн магадлалд хэргийн харьяалал зөрчигдсөн байдал, үндэслэлийг тодорхой зааж, харьяалах шүүхэд хандах эрхийг тусгана.

-иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.1.4.-т зааснаар шийдвэрийг хүчингүй болгож, мөн хуулийн 117 дугаар зүйлд зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Шүүхийн магадлалд хэргийн харьяалал зөрчигдсөн байдал, үндэслэлийг тодорхой зааж, харьяалах шүүхэд хандах эрхийг тодорхой тусгана.

е/ Хэргийн харьяалал зөрчигдсөн байдал дагнасан болон ерөнхий харьяаллын хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илэрвэл шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 178 дугаар зүйлийн 178.1.4.-т заасанаар шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

**2.1.4.** Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болсон захиргааны актын хууль зүйн үндэслэлийн талаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарсан болох нь илэрвэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4., 80 дугаар зүйлийн 80.1.4.-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарсан үед мөн зүйлийн 80.3.-т зааснаар сэргээх ажиллагааг гүйцэтгэнэ.

**2.2.Шүүхийн харьяалал**

Хэргийн харьяаллын хувьд дагнасан эсхүл ерөнхий харьяаллын шүүхэд хамаарч байгаа тухайн нэхэмжлэлийг дагнасан буюу ерөнхий харьяаллын ямар шүүх хянан шийдвэрлэхийг шүүхийн харьяалал тодорхойлно.

Тухайн нэхэмжлэлийг дагнасан эсхүл ерөнхий харьяаллын шүүх хянан шийдвэрлэх асуудал шүүхийн харьяаллаар бус харин хэргийн харьяаллаар тодорхойлогдоно.

**3.Зарим төрлийн маргааны харьяалал**

**3.1.Хөдөлмөрийн эрх зүйн маргаан**

Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлд заасан хөдөлмөрийн эрх зүйн маргаан нь шүүхэд харьяалагдах бөгөөд тэдгээрийн дотор

ажил олгогчийн санаачилгаар ажлаас буруу халсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн тухай ажилтны гомдлыг ерөнхий харьяаллын шүүхүүд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арвандөрөвдүгээр бүлэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.-д заасан төрийн улс төрийн, тусгай, захиргааны албан хаагчдын ажлаас үндэслэлгүй халагдсан тухай маргаантай хэргийг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх бөгөөд энэ тохиолдолд ажлаас халах шийдвэрийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтан гаргасан байх шаардлагатай. Бусад тохиолдолд төрийн улс төрийн, тусгай, захиргааны албан хаагчийг ажлаас халсан асуудлыг ерөнхий харьяаллын шүүх хянан шийдвэрлэнэ.

Төрийн үйлчилгээний албан хаагчийг ажлаас халах шийдвэрийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтан гаргасан хэдий ч хөдөлмөрийн эрхийн харилцаа хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр үүсдэг тул тухайн асуудлаарх маргааныг ерөнхий харьяаллын шүүх хянан шийдвэрлэнэ.

Төрийн жинхэнэ албан хаагч ажлаас үндэслэлгүй халагдсан гэж үзвэл гомдлоо Төрийн албаны салбар зөвлөл болон төрийн албаны төв байгууллагад гаргах боломжтой бол улс төрийн болон үйлчилгээний албан хаагчийн хувьд ийм боломж байдаггүйг шүүхүүд анхаарвал зохино.

Захиргааны хэргийн шүүх төрийн албан хаагчийн ажлаас халагдсан асуудлыг хянан шийдвэрлэхдээ Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.-д зааснаар төрийн албан хаагчийн хөдөлмөрийн тухайн харилцаатай холбоотой бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн зохицуулалтаар нэг мөр шийдвэрлэнэ.

**3.2.Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой маргаан**

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгэлийн байгууллагад холбогдох асуудлыг захиргааны болон ерөнхий харьяаллын шүүхүүд тухайн нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлээс хамааран өөр өөрийн харьяаллаар хянан шийдвэрлэнэ

Бүртгэлийн байгууллага, түүний албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас эд хөрөнгийн улсын бүртгэл буруу хийгдсэн тул бүртгэлийг хууль бус гэж тооцуулах, бүртгэл болон түүний үндсэн дээр олгогдсон гэрчилгээг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэнэ.

Харин өмчийн болон гэрээний эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэсний үр дүнд хууль ёсоор хийгдсэн улсын бүртгэлийг өөрчлөх, хүчингүй болгох асуудал иргэний хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий харьяаллын шүүхийн ажиллагаанд хамаарна. Энэ тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага иргэний хэрэгт хариуцагчаар оролцохгүй.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон эд хөрөнгийн улсын бүртгэл, түүний үндсэн дээр олгогдсон гэрчилгээ хууль бус байсныг захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээр хожим тогтоож, хүчингүй болговол энэ шийдвэр нь иргэний хэргийн шийдвэрт шинээр илэрсэн нөхцөл байдал болно.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эд хөрөнгийн улсын бүртгэл илтэд үндэслэлгүй, хууль бус болох нь илэрхий байвал ерөнхий харьяаллын шүүх эд хөрөнгийн бүртгэлд үндэслэгдсэн иргэний эрх зүйн маргааныг шийдвэрлэж, захиргааны хэргийн шүүхэд хандах хэргийн оролцогчийн эрхийг шийдвэртээ заавал тусгасан байна.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дээрх бүртгэлийн хууль зүйн үндэслэлийн талаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргавал шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4., 80 дугаар зүйлийн 80.1.4.-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарсан үед мөн зүйлийн 80.3.-т зааснаар сэргээх ажиллагааг гүйцэтгэнэ.

**3.3.Татварын харилцаанаас үүсэх маргаан**

Татварын Ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийн е-д зааснаар татварын өр, төлбөрийг барагдуулах тухай татварын улсын байцаагчийн нэхэмжлэлийг ерөнхий харьяаллын шүүх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ.

Татварын улсын байцаагчийн актад татвар төлөгч шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх журмын дагуу Татварын маргаан таслах зөвлөлд гомдол, Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд уг актын хууль зүйн үндэслэлийн талаарх хариуцагчийн сөрөг шаардлагыг ерөнхий харьяаллын шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 73 дугаар зүйлд заасан сөрөг нэхэмжлэл гэж үзэхгүй.

Харин татварын улсын байцаагчийн акт хууль зүйн үндэслэлгүй болох нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээр хожим тогтоогдвол захиргааны хэргийн шүүхийн шийдвэр иргэний хэргийн шийдвэрт шинээр илэрсэн нөхцөл байдал болно.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад татварын улсын байцаагчийн акт илтэд үндэслэлгүй, хууль бус болох нь илэрхий байвал ерөнхий харьяаллын шүүх татвар төлөгчийн захиргааны хэргийн шүүхэд хандах эрхийг шийдвэртээ заавал тусгана.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад татварын улсын байцаагчийн актын хууль зүйн үндэслэлийн талаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарвал шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4., 80 дугаар зүйлийн 80.1.4.-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарсан үед мөн зүйлийн 80.3.-т зааснаар сэргээх ажиллагааг гүйцэтгэнэ.

### 3.4.Сонгуулийн холбогдолтой маргаан

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6.-д заасан "Сонгуулийн Ерөнхий хороо" гэсэн заалтыг Үндсэн хуулийн Цэц 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлтээр Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоож, Улсын Их Хурал 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар уг заалтыг хүчингүй болсонд тооцсон тул Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэр, үйл ажиллагааны талаарх нэхэмжлэл захиргааны хэргийн шүүхийн харьяаланд хамаарахгүй.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн болон Сонгуулийн төв байгууллагын тухай, Орон нутгийн хурлын сонгуулийн тухай, Ард нийтийн санал асуулгын тухай хуулиудад Сонгуулийн Ерөнхий хороонд холбогдох маргааны харьяаллын талаар тусгайлсан зохицуулалт байхгүй бол энэ талаар гаргасан нэхэмжлэлийг ерөнхий харьяаллын шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арван дөрөвдүгээр зүйлд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

Дээрх хуулиудад Сонгуулийн Ерөнхий хорооноос бусад байгууллага, албан тушаалтанд холбогдох маргааны харьяаллыг тусгайлан заагаагүй бол нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүх Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1., 4.2.-т заасан үндэслэлээр өөрийн харьяаллаар, бусад тохиолдолд ерөнхий харьяаллын шүүхүүд өөрийн харьяаллаар тус тус хүлээн авч, хянан хэлэлцэнэ.

### 3.5.Ашигт малтмалын хууль тогтоомжтой холбоотой маргаан

Ашигт малтмалын тухай хуульд зааснаар төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны талаарх нэхэмжлэл захиргааны хэргийн шүүхэд харьяалагдана.

Иргэд, хуулийн этгээдүүдийн хоорондох гэрээний харилцаанаас үүссэн маргааныг иргэний журмаар хянан шийдвэрлэсний үр дүнд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, тэдгээртэй холбоотой бүртгэлийг өөрчлөх асуудлыг ерөнхий харьяаллын шүүх тухайн иргэний хэрэгт нэг мөр шийдвэрлэнэ. Энэ асуудлыг шийдвэрлэхэд төрийн захиргааны байгууллага иргэний хэрэгт хариуцагчаар оролцохгүй.

**4**.Хэргийн болон шүүхийн харьяаллын талаар шүүхүүд маргаж болохгүй бөгөөд хэргийн харьяаллыг тогтооход хүндрэлтэй тохиолдолд уг асуудлыг Шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4.-т зааснаар Улсын Дээд шүүхийн иргэний болон захиргааны хэргийн танхимын тэргүүн шийдвэрлэнэ.

Түүнчлэн Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд "аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ" гэж заасны дагуу хэргийн харьяаллыг Үндсэн хуулийн Цэц тогтоосон бол дагнасан болон ерөнхий харьяаллын шүүх түүний шийдвэрийг дагаж мөрдөнө.

**5**. Энэ тогтоолын хавсралт болох хүчин төгөлдөр үйлчилж байгаа 357 хуульд заагдсан хэргийн харьяаллын талаарх зохицуулалтын жагсаалтыг захиргааны болон ерөнхий харьяаллын шүүхүүд Улсын Дээд шүүхийн зөвлөмж хэлбэрээр ашиглах нь зүйтэйг дурдсугай.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ С.БАТДЭЛГЭР**

**ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМЫН ТЭРГҮҮН Ц.АМАРСАЙХАН**

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМЫН ТЭРГҮҮН О.ЗАНДРАА**

*Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 32 дугаар тогтоолын хавсралт*

## МОНГОЛ УЛСАД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ҮЙЛЧИЛЖ БАЙГАА ХУУЛИУД
/2007 оны 2 дугаар сарын 09-ний байдлаар/

| Д/д | Хуулийн нэр | /Батлагдсан он, сар, өдөр/ | /Хүчин төгөлдөр болсон он, сар, өдөр/ | Захиргааны хэргийн шүүх | Иргэний хэргийн шүүх |
|---|---|---|---|---|---|
| 1. | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль | 92-12-01 | 93-01-01 | Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 2. | Агаарын тухай хууль | 95-03-31 | 95.06.05 | Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, байгаль орчны тэнцлийг хангах өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхолд нийцүүлэн хийн мандлын агаар /цаашид "агаар" гэх/-ыг хамгаалах, түүнийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 3. | Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай | 95-05-22 | 1995.07.01 | Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан, шувуу, загас / цаашид "ан амьтан" гэх/ агнах, барих зөвшөөрлийн хураамж ногдуулах, уг төлбөр, хураамжийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 4. | Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хууль | 95-06-02 | 1995.06.06 | Энэ хуулийн зорилт нь автобензин, дизелийн түлшинд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 5. | Ард нийтийн санал асуулгын тухай хууль | 95-10-19 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 27 дугаар зүйл. Санал асуулгын талаарх маргааныг Үндсэн хуулийн цэц, шүүх, Сонгуулийн ерөнхий хороо, нутаг дэвсгэрийн болон хэсгийн хороод хууль тогтоомжид заасан харьяалал, журмын дагуу шийдвэрлэнэ. | |
| 6. | Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хууль | 96-08-27 | 1996.08.29 | 14 дүгээр зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалтын талаар гомдол гаргах<br>1.Сонгогчийг сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгээгүй буюу буруу бүртгэсэн байвал тэрээр тухайн сонгуулийн хэсгийн хороонд гомдол гаргах эрхтэй.<br>2.Сонгуулийн хэсгийн хороо уг гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор хянан үзэж, сонгогчдын нэрийн жагсаалтад зохих өөрчлөлт оруулах буюу гомдлыг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргаж, хариу мэдэгдэнэ. Сонгогч уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.<br>37 дугаар зүйл. Сонгуулийн холбогдолтой маргааныг шийдвэрлэх<br>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн талаарх аливаа маргааныг Үндсэн хуулийн цэц, шүүх, сонгуулийн хороод хууль тогтоомжид заасан харьяалал, журмын дагуу шийдвэрлэнэ | 11. Сонгуулийн зардлын сангаас зориулалтын бусаар зарцуулсан хөрөнгийг шүүх гэм буруутай этгээдээр гаргуулан улс, орон нутгийн төсөвт оруулна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Аудитын тухай хууль | 97-05-01 | 1997.09.01 | 11 дүгээр зүйл. Үйлчлүүлэгч байгууллагын эрх, үүрэг<br>1. Үйлчлүүлэгч байгууллага дараахь эрх эдэлнэ:<br>1/аудитын байгууллагыг сонгох;<br>2/аудитын дүгнэлтийн талаар тайлбар өгөхийг шаардах;<br>3/аудитын дүгнэлтийг зөвшөөрөхгүй бол энэ талаар шүүхэд гомдол гаргах.<br>22 дугаар зүйл. 4. Мэргэшсэн нягтлан бодогч сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно. | 32 дугаар зүйл. 3. Аудитын үйл ажиллагаа явуулах лиценз, зөвшөөрөлгүйгээр энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчлийг давтан үйлдсэн хуулийн этгээдийг татан буулгах асуудлыг шүүх холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. |
| 8 | Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль | 97-06-05 | 97.07.01 | | |
| 9 | Ажлын таван өдөртэй долоо хоногт шилжүүлэх тухай | 97-12-04 | 98.01.01 | 1 дүгээр зүйл. Бүх аж ахуйн нэгж, байгууллагыг 1998 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ажлын таван өдөртэй долоо хоногт шилжүүлсүгэй. | |
| 10 | Архивын тухай хууль | 98-01-02 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 7.5. Архивын хосгүй үнэт, үнэт баримт гэмтэх, устаж үрэгдэж болох нөхцөлд байгаа, эсхүл өмчлөгч нь сайн дураар шилжүүлэхээс татгалзсан, бусдын өмчлөлд байгаа архивын баримтыг нөхөх олговортойгоор төрийн мэдэлд шилжүүлэх асуудлыг төрийн архивын хүсэлтээр шүүх шийдвэрлэнэ. | |
| 11 | Авто замын тухай | 98-01-02 | 98.02.01 | 22 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх<br>22.1. Олон улсын болон улсын чанартай авто замын ашиглалтаас үүссэн маргааныг төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.<br>22.2. Орон нутгийн чанартай болон аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто замын ашиглалтаас үүссэн маргааныг сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.<br>22.3. Энэ зүйлийн 1, 2-т заасан эрх бүхий байгууллагын шийдвэрийн талаар гомдлоо шүүхэд гаргаж болно. | |
| 12 | Ариун цэврийн тухай хууль | 98-05-07 | 98.07.01 | Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрхийг баталгаажуулах зорилгоор ариун цэврийг сахиулах, түүний хэвийн нөхцөлийг хангуулах ерөнхий шаардлагыг тодорхойлох, энэ талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх, хүлээх хариуцлагыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 13 | Авто тээврийн тухай | 99-06-04 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | Бусад | 9 дүгээр зүйл. Тээвэрлэлт гүйцэтгэх<br>9.1. Тээвэрлэлтийг Иргэний хууль болон энэ хуульд нийцсэн гэрээний дагуу гүйцэтгэнэ.<br>12 дугаар зүйл. Тээвэрлэлтийн үнэ, хөнгөлөлт<br>12.1. Зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ хөлсний хэмжээг оролцогч талуудын тохиролцож байгуулсан гэрээгээр тогтооно. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14 | Архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ | 00-01-28 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1.1. Энэ хуулийн зорилт нь согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах /үйлчлэх/, хэрэглэх, архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 15 | Амьтны аймгийн тухай | 00-05-05 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1.1. Энэ хуулийн зорилт нь газар, ус, хөрсөнд байгалийн жамаараа амьдардаг, Монгол Улсын нутаг дэвсгэр дэх унаган, нутагшсан буюу нүүдлийн амьтад (цаашид "амьтан" гэх)-ыг хамгаалах, өсгөн үржүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | 10.2. Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол төлбөрийг бүрэн төлж ан агнах, барих эрхийн бичиг, гэрээ, тусгай зөвшөөрөлд заасан тоо хэмжээнд багтаан бэлтгэсэн ангийн түүхий эд нь бэлтгэгч этгээдийн өмч болно. |
| 16 | Ан агнуурын тухай | 00-05-05 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1.1. Энэ хуулийн зорилт нь агнуурын амьтныг агнах, барих, агнуурын нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 17 | Аялал жуулчлалын тухай | 00-05-05 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчны үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино | 9.2.Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг Иргэний хуулийн 370-379 дүгээр зүйл, энэ хууль, аялал жуулчлалын байгууллага жуулчинтай байгуулсан гэрээгээр зохицуулна. |
| 18 | Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай | 2000-11-03 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрийг аюултай хог хаягдлаас хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 19 | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай | 01-02-01 | 02.01.01 | 1.1. Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино. | |
| 20 | Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай | 01-04-12 | 01.06.01 | 1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэнийг гадаадад, гадаадын иргэнийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх /цаашид "ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах" гэх/, тэдний эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 21 | "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай | 02-06-28 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 4 дүгээр зүйл. Орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх, албан татвараас чөлөөлөх<br>5 дугаар зүйл. Газрын төлбөрийн хөнгөлөлт | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 22 | Амьтан, ургамал, түүнээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай | 02-11-28 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 31.1. Иргэн, хуулийн этгээд улсын байцаагчийн хооронд амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, хорио цээрийн үзлэг, шалгалт хийхтэй холбогдон үүссэн маргааныг улсын мэргэжлийн хяналтын байгууллага шийдвэрлэх бөгөөд тухайн шийдвэрийг эс зөвшөөрвөл иргэн, хуулийн этгээд, улсын байцаагч нь шүүхэд гомдол гаргаж болно | |
| 23 | Арбитрын тухай | 03-05-09 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | 1.1. Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаанд арбитрын ажиллагаа явуулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино. |
| 24 | Агаарын зайг нисэхэд ашиглах тухай | 03-05-30 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | Монгол Улсын Засгийн газраас агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журмыг тогтоож, хэрэгжилтэд нь хяналт тавина. | |
| 25 | Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай | 2003-11-28 | 04.07.01 | 1.1. Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, булах болон түүхий эдийн эх үүсвэр болгон дахин ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 26 | Ахмад настны нийгмийн хамгааллын тухай | 2005-12-08 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1.1.Энэ хуулийн зорилт нь ахмад настанд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээний төрөл, хэмжээг тогтоож, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын энэ талаар хүлээх эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 27 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай | 2006-06-29 | 2007.01.01 | 1.1.Энэ хуулийн зорилт нь аж ахуйн нэгжийн орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 28 | Авлигын эсрэг хууль | 2006-07-06 | 2006.11.01 | 1.1.Энэ хуулийн зорилт нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 29 | Ашигт малтмалын тухай | 2006-07-08 | Дагаж мөрдөх журмын тухай хуульд зааснаар | 56.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 56.4-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцалсан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд шүүх тухайн шийдвэрийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 46.1.3-т заасны дагуу түдгэлзүүлэхгүй. | 14.7.Энэ хуулийн 14.5-д заасны дагуу тогтоосон нөхөх олговортой холбогдсон маргаан гарвал шүүх хянан шийдвэрлэнэ. 63.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хооронд тухайн газарт нэвтрэн орох, дамжин өнгөрөх, ашиглах талаар гарсан маргааныг шүүх Иргэний хууль, Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 30 | Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | 2006-07-08 | | захиргаа | |
| 31 | Авлигын эсрэг хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай | 2007-02-06 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | |
| 32 | Бууны албан татварын хууль | 93-05-11 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1. Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж байгаа бууrigh албан татвар ногдуулах, уг албан татварыг улсын төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 33 | Батлан хамгаалахын тухай хууль | 93-10-12 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог тогтоож, төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эх орноо батлан хамгаалах талаар хүлээх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 34 | Байгаль орчныг хамгаалах тухай хууль | 95-03-30 | 95-06.05 | Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. | |
| 35 | Байгалийн ургамлын тухай | 95-04-11 | 95-06.05 | Энэ хуулийн зорилт нь ой болон таримал ургамлаас бусад ургамал /цаашид "ургамал" гэх/-ыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 36 | Байгууллагын нууцын тухай хууль | 95-05-16 | 95-07.01 | Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан этгээд хуулиар тогтоосон нууцыг нь бусдад задруулсан гэж үзвэл байгууллага энэ тухай гомдлоо шүүхэд гаргах эрхтэй. | |
| 37 | Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай | 95-05-19 | 95-06.05 | Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн ургамал /цаашид "ургамал" гэх/ ашигласны төлбөр ногдуулах, уг төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 38 | Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр, тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль | 95-10-31 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдээс банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд мөнгөн хөрөнгө хадгалуулах, хоорондын төлбөр тооцоогоо банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэх, банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл авах, түүнийг эргүүлэн төлөх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 39 | Банкны тухай хууль | 96-09-03 | 96-10.01 | Энэ хуулийн зорилт нь банк байгуулах зөвшөөрөл олгох, түүнийг хүчингүй болгох, банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, банкны үйл ажиллагаанд хяналт тавих, банкинд албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино | |
| 40 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай | 98-01-22 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1.1. Энэ хуулийн зорилт нь байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцэл алдагдахаас сэргийлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах, төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, төслийг хэрэгжүүлэх эсэх талаар шийдвэр гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино | |
| 41 | Барилгын тухай хууль | 98-08-07 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | Энэ хуулийн зорилт нь инженерийн хийцтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, ашиглах, техникийн хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.<br>18 дугаар зүйлийн 18.3. Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрийн талаар гарсан маргааныг түүний дээд шатны улсын байцаагч хянан шийдвэрлэнэ. Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн шийдвэр үндэслэлгүй байвал түүнийг дээд шатны улсын байцаагч хүчингүй болгоно. Барилгын техникийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн шийдвэрийн талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ. | 4 дүгээр бүлэг. Барилгын захиалагч, гүйцэтгэгч, материал үйлдвэрлэгч,<br>зураг төсөл зохиогчийн эрх, үүрэг |
| 42 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай | 00-01-28 | 00-10.01 | 1.1. Энэ хуулийн зорилт нь байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилан зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг /цаашид "төлбөрийн орлогын хэсэг" гэх/ тогтооход оршино. | |
| 43 | Боловсролын тухай | 02-05-03 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1.1.Энэ хуулийн зорилт нь боловсролын үндсэн зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, иргэний сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино. | 25.4.Боловсролын сургалтын байгууллага татан буугдсан болон суралцагчид учирсан хохирлыг арилгуулахтай холбоотойгоор үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.<br>25.5.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгахтай холбогдон үүсэх эд хөрөнгийн харилцааг иргэний хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна. |
| 44 | Бага, дунд боловсролын тухай | 02-05-03 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1.1.Энэ хуулийн зорилт нь иргэнд сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 45 | Бага, дунд боловсролын тухай хуулийг дагаж мөрдөх тухай | 02-05-03 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | |
| 46 | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай | 02-12-12 | 03.02.01 | Зөвшөөрөл олгохтой холбоотой болон хяналт шалгалт хийхтэй холбоотой заалтууд<br>20.4.Энэ хуулийн 20.1-д заасан торгуулийг үндэслэлгүй ногдуулсан гэж үзвэл шүүхэд гомдол гаргаж болно. | 1.1. Энэ хуулийн зорилт нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино. |
| 47 | Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай | 03-05-02 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 28.1. Сонирхогч этгээд энэ хуулийн 5.2, 5.3, 5.4-т заасныг зөрчиж барааны тэмдгийг, 15.2, 15.3-т заасныг зөрчиж газар зүйн заалтыг бүртгэсэн гэж үзвэл уг тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгох тухай хүсэлтээ шүүхэд гаргаж болно.<br>29.3. Маргааныг хянан шийдвэрлэсэн оюуны өмчийн байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл маргагч талууд шийдвэрийг хүлээн авснаас хойш 2 сарын дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.<br>29.4. Оюуны өмчийн байгууллагад хуулиар харъяалуулснаас бусад гомдол, маргааныг шүүх хүлээн авч шийдвэрлэнэ. | |
| 48 | Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай | 03-05-30 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 18.1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, Зөвлөлийн хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Засгийн газар шийдвэрлэнэ. | |
| 49 | Биеийн тамир, спортын тухай | 03-10-31 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1.1. Энэ хуулийн зорилт нь биеийн тамир, спортын зохион байгуулалт, эдийн засаг, эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнд оролцогчдын хооронд үүссэн харилцааг зохицуулахад оршино. | |
| 50 | Валютын зохицуулалтын тухай хууль | 94-05-12 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | Энэ хуулийн зорилт нь валютын зохицуулалтын талаарх төрийн зохих байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд валютын гүйлгээ хийх, валютын гүйлгээнд хяналт тавих, Монгол Улсын үндэсний валютыг үнэгүйдлээс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | 17 дугаар зүйлийн 6. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн валютын гүйлгээний талаарх маргааныг шүүхээр шийдвэрлэнэ. |
| 51 | Вексолийн тухай хууль | 95-11-02 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | 18 дугаар зүйл 1. Төлбөр хариуцагч вексельд заасан төлбөрийн хугацаанд төлбөрөө гүйцэтгээгүйтэй холбогдон гарсан маргааныг шүүх зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.<br>2. Нийлүүлсэн бараа, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр тооцоог вексолиор хийх, энэ харилцаатай холбогдон гарсан маргааныг Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 52 | Газрын хэвлийн тухай хууль | 88-11-29 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт нь өнөөгийн болон хойч үеийнхний ашиг сонирхолд нийцүүлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон нийгмийн харилцааг зохицуулахад оршино. | 56 дугаар зүйлийн 2. Газрын хэвлийг ашиглах асуудлаар гарсан эд хөрөнгийн маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ. |
| 53 | Газрын тосны тухай хууль | 91-01-18 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | Монгол Улсын газрын тосны тухай хуулийн зорилт нь Монгол Улсын болон гадаад улсын байгууллага, иргэдээс тус улсын газрын хэвлийд орших бүх газрын тосыг хайх, хамгаалах, олборлох, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | 13 дугаар зүйлийн 1. Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад үүссэн эд хөрөнгийн маргааныг газрын тосны тухай гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын шүүх Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хянан шийдвэрлэнэ. |
| 54 | Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль | 93-05-10 | 93-07.01 | 14 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх<br>15 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбар, хөрөнгө оруулалтын гэрээг бүртгэх<br>18 дугаар зүйл. Татвар ногдуулах<br>19 дүгээр зүйл Тогтвортой байдлын гэрээ<br>21 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбарт газар ашиглуулах | 25 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулагч болон монголын хөрөнгө оруулагчийн хооронд, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагч болон монголын хуулийн этгээд, хувь хүний хооронд гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбарын үйл ажиллагаатай холбогдон үүссэн маргааныг Монгол Улсын олон улсын гэрээ, талуудын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын шүүх шийдвэрлэнэ. |
| 55 | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль | 93-12-24 | 94.02.01 | 25 дугаар зүйлийн 3. Монгол Улсад цагаачлан ирсэн гадаадын иргэн жилд 120 хоногоос дээш хугацаагаар тус улсын нутаг дэвсгэрт байгаагүй бол цагаачлан суух зөвшөөрлийг цуцлах эсэхийг Алба тухай бүр хянан шийдвэрлэнэ. Цагаачлан суух зөвшөөрлийг буцаан авахаар шийдвэрлэсэн бол энэ тухай цагаачлан суугаа гадаадын иргэнд мэдэгдэх бөгөөд тухайн хүн уг шийдвэрийг эс зөвшөөрвөл мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй. | |
| 56 | Гаалийн тухай хууль | 96-05-16 | 96-07.01 | 89 дүгээр зүйлийн 3. Давж заалдах гомдлын талаар зохих дээд шатны эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй. | 87 дугаар зүйлийн 2. Гаалийн хууль тогтоомж зөрчсөний улмаас хураагдсан бараа, тээврийн хэрэгсэл уг зөрчилд холбогдолгүй болох нь гаалийн удирдах төв байгууллага, эсхүл шүүхийн шийдвэрээр нотлогдвол түүнийг буцаан олгох бөгөөд хэрэв буцаан олгох боломжгүй бол гаалийн байгууллагын борлуулсан үнийг эргүүлж олгоно. |
| 57 | Гаалийн тарифын тухай хууль | 96-05-20 | 96-07.01 | Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын гаалийн тарифын тогтолцоог бүрдүүлэх, гаалийн татварын хувь, хэмжээг тогтоох зарчим, гаалийн үнийг тодорхойлох, гаалийн татвар ногдуулах, барагдуулахад дагаж мөрдөх журмыг тогтооход оршино. | |
| 58 | Газрын төлбөрийн тухай хууль | 97-04-24 | 97-07.01 | Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн өмчийн газрыг эзэмшиж, ашигласны төлөө төлбөр ногдуулах, уг төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.<br>11 дүгээр зүйлийн 2. Төлбөр төлөгч газрын төлбөртэй холбогдсон маргааны талаар энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл уг маргааныг шүүх шийдвэрлэнэ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 59 | Геодези, зураг зүйн тухай | 97-10-31 | 97-11-15 | 1.1. Энэ хуулийн зорилт нь геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, тэдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино. | |
| 60 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай | 97-12-04 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1.1. Энэ хуулийн зорилт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, үндсэн чиглэл, төрөл, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 61 | Гүйцэтгэх ажлын тухай хууль | 97-12-19 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 7.2. Гүйцэтгэх байгууллага, түүний ажилтан нь хуулиар олгосон эрх хэмжээгээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж хууль бусаар иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан байгууллага, албан тушаалтан болон шүүх зөрчигдсөн эрхийг нь сэргээж, учирсан хохирлыг арилгах арга хэмжээг тус тусын чиг үүрэг, хууль тогтоомжид заасны дагуу авна. | |
| 62 | Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хууль | 98-01-08 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 12.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын цэргийн хүчин байрлах, дамжин өнгөрөхдөө олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг зөрчвөл Монгол Улс Олон улсын шүүхэд хандана. | |
| 63 | Гэр бүлийн тухай | 99-06-11 | 99-08-01 | 22.1. Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эх хамтарч, эсхүл хүүхдийн эцэг, эх болох нь тогтоогдоогүй эцэг буюу эх өөрөө өргөдөл гаргасан бол иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллага эцэг, эхийг тогтооно.<br>25.5. Бүтэн өнчин, эцэг, эх нь хөдөлмөрийн эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах боломжгүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх, ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаална.<br>25.6. Энэ хуулийн 25.4, 25.5-д заасан хүүхдийн тухай мэдээллийг ясли, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлгийн байгууллагын холбогдох албан тушаалтан болон иргэн хүүхдийн оршин суугаа /оршин байгаа/ газрын сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй.<br>25.7. Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль1-ийн 2 дугаар зүйлд заасны дагуу цагдаагийн байгууллагаас шилжүүлсэн хүүхдийг хүлээн авсан хүүхдийн буюу хүргалзан дэмжих байгууллага нь гурав хоногийн дотор энэ тухай сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх үүрэгтэй.<br>25.8. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 25.6, 25.7-д заасан хүүхдийн тухай мэдээллийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор хүүхдийн | 1.1. Энэ хуулийн зорилт нь гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, нөхцлийг тогтоож, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | амьдралын нөхцөлийг судалж, эцэг, эх болон төрөл садангийн хүн байхгүй нь тогтоогдсон бол түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ.<br>55.7. Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана.<br>55.8. Хүүхэд үрчилсэн тухай шийдвэрийг үндэслэн иргэний гэр бүлийн бүртгэлийн ажилтан хүүхэд үрчилснийг бүртгэнэ.<br>71 дүгээр зүйл. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагааны талаар Засаг даргын эдлэх эрх | |
| 64 | Галын аюулгүй байдлын тухай | 99-05-28 | 99-07-01 | 1.1. Энэ хуулийн зорилт нь галын аюулгүй байдлыг хангах, галын аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын эрх зүйн үндсийг тогтоох, галын аюулгүй байдлыг хангах талаархи нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |
| 65 | Гэрээт харуул хамгаалалтын тухай | 00-01-20 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 5.1. Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/-т бүртгүүлнэ. | 8.4. Гэрээний Талуудын хооронд гарсан маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ. |
| 66 | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай | 00-04-06 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | |
| 67 | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай | 00-07-26 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | |
| 68 | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай | 00-12-07 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | |
| 69 | Галт зэвсгийн тухай | 01-04-26 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 19.1. Дор дурдсан тохиолдолд цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, гаалийн байцаагч галт зэвсгийг хураах, 30 хоногийн дотор цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.<br>19.5. Энэ хуулийн 19.1-д заасан шийдвэрийг зөвшөөрөхгүй бол тухайн этгээд шүүхэд гомдол гаргах эрхтэй. | |
| 70 | Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай | 01-05-25 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 71. | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай | 01-10-18 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | |
| 72. | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай | 02.01.10 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | |
| 73. | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай | 02.06.06 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | |
| 74. | Газрын тухай | 02-06-07 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 40.3. Эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь Засаг даргын шийдвэрийг хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор **шүүх**эд гомдол гаргах эрхтэй.<br>60.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газартай холбогдон үүссэн маргааны талаар энэ хуулийн 60.1.1, 60.1.2, 60.1.3-т заасан байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг маргааныг тэдгээрийн дээд шатны албан тушаалтан, байгууллага, эсхүл **шүүх**ээр шийдвэрлүүлнэ.<br>61.1. Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл **шүүх** уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно. | 60.1.4. бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах талаар болон газартай холбогдон үүссэн эд хөрөнгийн маргааныг **шүүх**. |
| 75. | Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай | 03-06-12 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | | |
| 76. | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай | 02.06.13 | | | |
| 77. | Гамшгаас хамгаалах тухай | 03-06-20 | Албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дараа | 1.1. Энэ хуулийн зорилт нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага болон гамшгаас хамгаалах албаны тогтолцоо, зохион байгуулалт, удирдлага, үйл ажиллагаа, гамшгаас хамгаалах асуудлаар төрийн болон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эдлэх эрх, хүлээх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | |

/Үргэлжлэл бий./

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 265958
Индекс 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 3